

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

**Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн тухай**

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 48 МВт-ын хүчин чадалтай дунд дараалтын хэсэг 1968-1975 онд, 100 МВт-ын хүчин чадалтай өндөр дараалтын хэсэг 1976-1981 онд ашиглалтад орж, 2014 онд 50 МВт-ын хүчин чадалтай турбингенератораар өргөтгөсөнөөр суурилагдсан хүчин чадал нь 198 МВт хүрсэн бөгөөд 56 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

Тус станц нь Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний гидравлик горимын хувьд хамгийн оновчтой байршилд байрладаг ба Улаанбаатар хотын дулаан хангамжийн хэрэглээний 32 хувийг, Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчиний 16 хувийг тус тус ханган ажилладаг.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчиний хэрэглээ жилд дунджаар 8-10 хувиар өсөж байгаа бөгөөд өвлүүн улиралд дулааны цахилгаан станцууд бэлтгэл тоноглолгүй ажиллаж байгаа нь насжилт өндөртэй тус станцын хувьд техникийн гэмтэл saatlaas шалтгаалан хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хязгаарлах эрсдэлтэй нөхцөлд байна. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд тус станцыг ойрын хугацаанд өргөтгөн шинэчлэх шаардлагатай юм.

Улаанбаатар хотын одоогийн болон өсөн нэмэгдэж буй эрчим хүчиний хэрэглээг найдвартай хангах зорилгоор Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгэн, шинэчлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний үе шатанд 50 МВт-ын дулааны станцыг шинээр барьж, дараагийн шатанд ашиглалтын хугацаа дууссан 48 МВт-ын станцыг буулган, суурин дээр нь 250 МВт-ын дулааны цахилгаан станцыг шинээр барина.

Энэхүү төслийн санаачлага нь Монгол Улсад 2016 онд зохион байгуулагдсан АСЕМ-ийн Дээд түвшний 11 дүгээр уулзалтын хүрээнд ОХУ-ын Засгийн газрын дарга Д.А.Медведевийн айлчлалын үеэр Оросын талаас Монгол Улсад ОХУ-ын экспортын хөнгөлөлттэй зээлийг эрчим хүч, төмөр замын салбарт олгох асуудал яригдаж эхэлсэн бөгөөд ОХУ-ын хөнгөлөлттэй зээлийн асуудлаар 2017 оны 08 дугаар сард ОХУ-ын Сангийн сайдын дулааны цахилгаан станцын шинэчлэлийн төсөлд ОХУ-ын талаас “Интер РАО” ХНК оролцох ба тус компанийт хамтран ажиллахыг зөвлөсөн байдаг.

ОХУ-ын хууль, тогтоомжийн дагуу ОХУ-ын экспортын зээл нь тухайн улсын компанийн гадны улсын компанийтай байгуулсан төсөл, арга хэмжээний гэрээг санхүүжүүлэх зориулалттай байдаг тул Эрчим хүчиний яам, “ДЦС-3” ТӨХК болон “Интер РАО” ХНК хооронд Дулааны гуравдугаар цахилгаан станцын 48 МВт-ын станцыг буулгаж, суурин дээр нь 250 МВт-ын дулааны цахилгаан станц шинээр барих төслийн нийт өртөг, хугацааг тохирох асуудлаар 2018-2019 онд хэлцэл хийсэн боловч үр дүнд хүрээгүй.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 2021 оны хуралдааны үеэр

Оросын талаас Интер РАО Экспорт компанийг Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгөн, шинэчлэх төсөлд оролцохыг дахин илэрхийлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2021 оны 12 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр “ДЦС-3” ТӨХК болон Интер РАО Экспорт компани хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, төслийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Интер РАО Экспорт компаниас төслийн ТЭЗҮ-г өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж 2022 оны 08 дугаар сард “ДЦС-3” ТӨХК-д хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэл болон Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24, 25 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станцыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийг хэрэгжүүлэхээр Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Эрчим хүчний яам, Интер РАО Экспорт компанийтай хамтран ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Эрчим хүчний яамнаас хоёр улсын Засгийн газар хооронд байгуулах Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажлын тухай хэлэлцээрийн төслийг 2023 оны 03 дугаар сард ирүүлсэн бөгөөд уг хэлэлцээрийн төслийг Эрчим хүчний яамны зүгзэс Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хурлаар соёрхон батлуулахад Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 300 МВт-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийн нийт төсөвт өртөг, барилга угсралтын ажлын хугацаа болон ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлийн нөхцөлийг харилцан тохиролцож тодорхой болгох шаардлага үүссэн.

Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, зээлийн нөхцөлийг тодорхой болгох хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатараас ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановт 2022 оны 01/1373, 2023 оны 01/333 тоот албан бичгүүдийг хүргүүлж, ОХУ-ын Сангийн сайдтай 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр тус улсын Сангийн яаманд уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үеэр төслийн санхүүжилтийн нөхцөлийн талаар хэлэлцэж, ОХУ-аас экспортын зээлийн нөхцөл нь зээлийн хүү 2 хувь, эргэн төлөх хугацаа 20 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил, Монголын талын хөрөнгө оруулалт 5 хувиас хэтрэхгүй байх, рублийн зээл авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Мөн Сангийн сайд Б.Жавхлангаас ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановт 2023 оны 06 сарын 06-ны өдөр Өрийн удирдлагын тухай хуульд заасан зээлийн хөнгөлөлтийн түвшинг харгалзан зээл олгох хүсэлтийг хүргүүлсэн.

Түүнчлэн 2023 оны 06 дугаар сард ОХУ-ын Санктпетербург хотноо зохион байгуулагдсан Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановтай Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөн шинэчлэх төслийн санхүүжилтийн талаар албан уулзалт хийсэн ба уг уулзалтаар ОХУ-ын Сангийн сайд Монголын талын санал болгосон хөнгөлөлттэй нөхцөлийн дагуу зээл олгох боломжгүй байгааг, мөн ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал сайжрахад төслийн санхүүжилтийг эргэн харах боломжтой байгаа талаар мэдэгдсэн болно.

Төслийн нийт төсөвт өртөг ОХУ-ын Интер РАО Экспорт компанийн 2022 онд боловсруулсан техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээр нийт 1,326.9 сая евро (НӨАТ-тай дун 1,486.9 сая евро) бөгөөд санхүүжилтийн 15 хувийг буюу 199 сая

еврог Монголын талаас, 85 хувийг буюу 1 тэрбум 127.9 сая еврог ОХУ-ын экспортын зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.

Эрчим хүчний яам болон “ДЦС-3” ТӨХК-аас уг төслийн ТЭЗҮ-г судалж, эрчим хүчний салбарт хэрэгжиж буй бусад дулааны цахилгаан станцын төслүүдийн жишиг үнийн тооцооллыг ашиглан Монголын тал өөрийн хөрөнгөөр тус төслийг санхүүжүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд 814.3 сая ам.доллараар (НӨАТ-тай дүн 915.1 сая ам.доллар) хэрэгжүүлэх, төслийн барилга угсралтын ажлын хугацааг нэгээс хоёр жилээр бууруулах боломжтой гэж үзсэн бөгөөд ОХУ-ын Интер РАО Экспорт компанийй тудаа дараа уулзалт хийж, төслийн нийт төсөвт өртгийг бууруулах саналыг танилцуулсан.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн 2023 оны 12 дугаар сард Москва хотод ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд бөгөөд Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.А.Козловтой уулзалт хийх үеэр Дулааны гуравдугаар цахилгаан станцыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгэн, шинэчлэх төслийн талаар санал солилцон, төслийн хэрэгжилтийг хангах замын зураглалыг шинэчлэн байгуулсан.

Төслийн шинэчилсэн замын зураглалын дагуу тус төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг бодитоор тодорхойлохын тулд эхний ээлжинд төслийн зураг төсөл боловсруулах ажлыг Монголын тал өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх, тухайн санхүүжилтийг хоёрдугаар ээлжинд барилга угсралтын ажлын нийт төсөвт Монголын талын гаргасан санхүүжилтэд оруулан тооцоohoор тохиролцсон.

Үүнтэй холбогдуулан Эрчим хүчний яамнаас “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, уг хэлэлцээрийн төсөлд Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яамдын саналыг авч нэгтгэн тусгаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр “Дулааны гуравдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгэн шинэчлэх төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн талаар хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд нарт даалгасан.

Үүний дагуу дээрх хэлэлцээрийн төслийг Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн a/1231 тоот албан бичгээр ОХУ-ын Эрчим хүчний сайд Н.Г.Шульгиновт Гадаад харилцааны яамаар дамжуулан хүргүүлсэн.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан ОХУ-ын Эрчим хүчний сайдын түрүүрэгч гүйцэтгэгч П.Ю.Сорокинаас Оросын талын саналыг дипломат шугамаар 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн бөгөөд тус Оросын талын саналыг судлан Монгол Улсын Эрчим хүчний яамны хариу саналыг ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилевт 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр дипломат шугамаар хүргүүлж, Эрчим хүчний яам хооронд 2024 оны 08 дугаар сард хэлэлцээрийн төслийг харилцан зөвшилцэх ажлыг зохион байгуулсан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн дагуу хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороодтой тус тус зөвшилцсэн. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын дүгнэлт, Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 48 дугаар “Гарын үсэг зурах эрх олгох тухай” захирамжийн дагуу хэлэлцээрт Монголын талаас Эрчим хүчний сайд гарын үсэг зурсан.

**Хэлэлцээрийн төслийн тухай:**

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад 2024 оны 09 дүгээр сард хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Монгол Улсын Эрчим хүчний сайд, Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд нар гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт-ын (1x50 МВт) блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48 МВт-ын (4x12 МВт) блок станцыг буулгаж суурин дээр нь 250 МВт-ын (2x125 МВт) блок станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах, инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар “ДЦС-3” ТӨХК, гүйцэтгэгчээр ОХУ-ын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгасан.

Зураг төсөл боловсруулах ажлын үр дүнд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг, хугацааг нарийвчлан тодорхойлж, цаашид ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлийн нөхцөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох нөхцлийг бүрдүүлэх суурь баримт бичиг болно.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

---оо---

## ТАНИЛЦУУЛГА

**Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэл болон Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24, 25 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станцыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийг хэрэгжүүлэхээр Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Эрчим хүчний яам, Интер РАО Экспорт компанийтай хамтран ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Эрчим хүчний яамнаас хоёр улсын Засгийн газар хооронд байгуулах Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажлын тухай хэлэлцээрийн төслийг 2023 оны 03 дугаар сард ирүүлсэн бөгөөд уг хэлэлцээрийн төслийг Эрчим хүчний яамны зүгээс Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хурлаар соёрхон батлуулахад Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 300 МВт-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийн нийт төсөвт өртөг, барилга угсралтын ажлын хугацаа болон ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлийн нөхцөлийг харилцан тохиролцож тодорхой болгох шаардлага үүссэн.

Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, зээлийн нөхцөлийг тодорхой болгох хүрээнд Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатараас ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановт 2022 оны 01/1373, 2023 оны 01/333 тоот албан бичгүүдийг хургуулж, ОХУ-ын Сангийн сайдтай 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр тус улсын Сангийн яаманд уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үеэр төслийн санхүүжилтийн нөхцөлийн талаар хэлэлцэж, ОХУ-аас экспортын зээлийн нөхцөл нь зээлийн хүү 2 хувь, эргэн төлөх хугацаа 20 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдхөх хугацаа 5 жил, Монголын талын хөрөнгө оруулалт 5 хувиас хэтрэхгүй байх, рублийн зээл авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Мөн Сангийн сайд Б.Жавхлангаас ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановт 2023 оны 06 сарын 06-ны өдөр Өрийн удирдлагын тухай хуульд заасан зээлийн хөнгөлөлтийн түвшинг харгалзан зээл олгох хүсэлтийг хургуулсан.

Түүнчлэн 2023 оны 06 дугаар сард ОХУ-ын Санктпетербург хотноо зохион байгуулагдсан Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтын үеэр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн ОХУ-ын Сангийн сайд А.Г.Силуановтай Дулааны гуравдугаар цахилгаан станцыг өргөтгөн шинэчлэх төслийн санхүүжилтийн талаар албан уулзалт хийсэн ба уг уулзалтаар ОХУ-ын Сангийн сайд Монголын талын санал болгосон хөнгөлөлттэй нөхцөлийн дагуу зээл олгох боломжгүй байгааг, мөн ОХУ-ын эдийн засгийн нөхцөл байдал сайжрахад төслийн санхүүжилтийг эргэн харах боломжтой байгаа талаар мэдэгдсэн болно.

Төслийн нийт төсөвт өртөг ОХУ-ын Интер РАО Экспорт компанийн 2022 онд боловсруулсан техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээр нийт 1,326.9 сая евро

(НӨАТ-тай дүн 1,486.9 сая евро) бөгөөд санхүүжилтийн 15 хувийг буюу 199 сая европг Монголын талаас, 85 хувийг буюу 1 тэрбум 127.9 сая европг ОХУ-ын экспортын зээлзээр санхүүжүүлэхээр тусгасан.

Эрчим хүчний яам болон “ДЦС-3” ТӨХК-аас уг төслийн ТЭЗҮ-г судалж, эрчим хүчний салбарт хэрэгжиж буй бусад дулааны цахилгаан станцын төслүүдийн жишиг үнийн тооцооллыг ашиглан Монголын тал өөрийн хөрөнгөөр тус төслийг санхүүжүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд 814.3 сая ам.доллараар (НӨАТ-тай дүн 915.1 сая ам.доллар) хэрэгжүүлэх, төслийн барилга угсралтын ажлын хугацааг нэгээс хоёр жилээр бууруулах боломжтой гэж үзсэн бөгөөд ОХУ-ын Интер РАО Экспорт компанийтай удаа дараа уулзалт хийж, төслийн нийт төсөвт өртгийг бууруулах саналыг танилцуулсан.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн 2023 оны 12 дугаар сард Москва хотод ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд бөгөөд Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.А.Козловтой уулзалт хийх үеэр Дулааны гуравдугаар цахилгаан станцыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийн талаар санал солилцон, төслийн хэрэгжилтийг хангах замын зураглалыг шинэчлэн байгуулсан.

Төслийн шинэчилсэн замын зураглалын (Танилцуулгын хавсралт 1) дагуу тус төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг бодитоор тодорхойлохын тулд эхний ээлжинд төслийн зураг төсөл боловсруулах ажлыг Монголын тал өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх, тухайн санхүүжилтийг хоёрдугаар ээлжинд барилга угсралтын ажлын нийт төсөвт Монголын талын гаргасан санхүүжилтэд оруулан тооцооюор тохиролцсон.

Үүнтэй холбогдуулан Эрчим хүчний яамнаас “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, уг хэлэлцээрийн төсөлд Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яамдын саналыг авч нэгтгэн тусгаж, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.

Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр “Дулааны гуравдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөн шинэчлэх төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн талаар хууль тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд, Сангийн сайд, Гадаад харилцааны сайд нарт даалгасан.

Үүний дагуу дээрх хэлэлцээрийн төслийг Эрчим хүчний сайдын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн a/1231 тоот албан бичгээр ОХУ-ын Эрчим хүчний сайд Н.Г.Шульгиновт Гадаад харилцааны яамаар дамжуулан хургуулсан.

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан ОХУ-ын Эрчим хүчний сайдын түрүүрэгч гүйцэтгэгч П.Ю.Сорокинаас Оросын талын саналыг дипломат шугамаар 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн бөгөөд тус Оросын талын саналыг судлан Монгол Улсын Эрчим хүчний яамны хариу саналыг ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилевт 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр дипломат шугамаар хүргүүлж, Эрчим хүчний яам хооронд 2024 оны 08 дугаар сард хэлэлцээрийн төслийг харилцан зөвшүүлж ажлыг зохион байгуулсан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн дагуу хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороодтой тус тус зөвшилцсэн. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодын дүгнэлт, Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 48 дугаар “Гарын үсэг зурах эрх олгох тухай” захирамжийн дагуу хэлэлцээрт Монголын талаас Эрчим хүчний сайд гарын үсэг зурсан.

**Хэлэлцээрийн төслийн тухай:**

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад 2024 оны 09 дүгээр сард хийсэн албан ёсны айлчлалын үеэр “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Монгол Улсын Эрчим хүчний сайд, Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд нар гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт-ын (1x50 МВт) блок станцаар өргөтгэх, дунд даралтын хэсгийн 48 МВт-ын (4x12 МВт) блок станцыг буулгаж суурин дээр нь 250 МВт-ын (2x125 МВт) блок станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах, инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар “ДЦС-3” ТӨХК, гүйцэтгэгчээр ОХУ-ын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгасан.

Зураг төсөл боловсруулах ажлын үр дунд Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг, хугацааг нарийвчлан тодорхойлж, цаашид ОХУ-ын Засгийн газрын экспортын зээлийн нөхцөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох нөхцлийг бүрдүүлэх суурь баримт бичиг болно.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

---оо---

## ОХУ-ЫН ТАЛТАЙ ТОХИРОЛЦОН ШИНЭЧИЛСЭН ЗАМЫН ЗУРГАЛАЛ

Монгол Улсын Улаанбаатар хотога АДС-3-ийн өргөтгөлийн Төслийн замын зураглал



2024 оны 3-р сар

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл

Чадлын түргэг  
төслийн замын  
түүхийн зорилжин  
гээдэг зорилжин  
хөгжлийн  
мэргэжлийн  
механизмын  
бийрхамжийн  
зүйнүүдэл